



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 11 сарын 27 өдөр

Дугаар 2/186

Цагаан-Уул сум

Г Ажлын хэсэг байгуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. 2024 онд Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх хөтөлбөрийн хүрээнд хийгдэх байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, техник хэрэгслүүд худалдан авах ажлуудын зардалын техникийн тодорхойлолт боловсруулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ахлагч: Н.Алтанбаатар (Засаг даргын орлогч)

Гишүүд: Н.Пүрэвбат (Байгаль хамгаалагч)

Н.Жанчивдорж (Байгаль хамгаалагч)

Б.Анхцэцэг (Төслийн ажилтан)

Нарийн бичгийн дарга: Ч.Эрдэнэчулуун (Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн)

2. Ажлын даалгавар боловсруулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, захиалагчид танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Н.Алтанбаатар)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ш.Эрдэнцэцэг)-т даалгасугай.

ДАРГА

С.ГОНЧИГНЯМ

